



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/508

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн “Гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн хэлтэс”-ийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн тус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,028,318.50 /гурван сая хорин найман мянга гурван зуун арван найман төгрөг, тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс” /Б.Даваажаргал/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 60,000 /Жаран мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 8 нэр төрлийн 2,968,318.50 /Хоёр сая есөн зуун жаран найман мянга гурван зуун арван найман төгрөг, тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс” /Б.Даваажаргал/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

11506 001273

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 10-р сарын 23-ны өдрийн . . . /508/ -р тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиг-ласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХК-н шийдвэр
1	Зургийн аппарат	4	ш	1	189,900.00	189,900.00	189,900.00	-	татах
2	Нөүтбүүк /Нотеbook/	4	ш	1	899,900.00	899,900.00	899,900.00	-	татах
3	Нөүтбүүк /Нотеbook Asus/	4	ш	1	1,060,700.00	1,060,700.00	1,060,700.00	-	татах
4	Дэлгэц	4	ш	1	114,950.00	114,950.00	114,950.00	-	татах
5	Принтер Laser jet	4	ш	1	180,909.10	180,909.10	180,909.10	-	татах
6	Тог баригч	4	ш	4	52,358.35	209,433.40	209,433.40	-	татах
7	DVD Тоглуулагч	4	ш	1	72,726.00	72,726.00	72,726.00	-	татах
8	Дуу хураагуур	4	ш	2	119,900.00	239,800.00	239,800.00	-	татах
Тоног төхөөрөмжийн дүн				12		2,968,318.50	2,968,318.50	-	
9	Бичиг хэргийн программ	4	ш	1	60,000.00	60,000.00	60,000.00	-	устгах
Биет бус хөрөнгийн дүн				1		60,000.00	60,000.00	-	
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				13		3,028,318.50	3,028,318.50	-	
Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө						2,968,318.50	2,968,318.50	-	
Актлах хөрөнгө						60,000.00	60,000.00	-	